

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/79/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:В.Эрдэнэцогт Утас: 51-260512 Цахим хаяг: Erdenetsogtv@audit.gov.mn Аудитор: Г.Батбилэг Утас:51-261628 Цахим хаяг: batbilegg@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.27 № 06/837
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 399.9 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Жилийн эцэст харилцагч байгууллагуудаас авах 13.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тус хорооны даргын 2025 оны А/75 дугаар тушаалаар 138.1 сая төгрөгийн нэмэгдэл цалин давхардуулан олгосон, оны шилдэг ажилтан шалгаруулж 20.8 сая төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон;
- Тус байгууллагын 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 65.8 сая төгрөгөөр хэтрүүлж, 115.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.
- Авто тээврийн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм мөрдөөгүйгээс тайлант хугацаанд автомашины сэлбэгийн зардалд 24.1 сая төгрөгийн зардал гаргасан.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зохицуулах хорооны 2025 оны 29 дүгээр тогтоолоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2025 онд төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрийг нэмэгдүүлж, 1м^3 усны үнийг 9.14 төгрөг болгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний орлогын төлөвлөгөөг 89.7 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Бусад асуудал

Зохицуулах хороо нь 2025 онд 22 зорилгын хүрээнд 134 арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Тусгай зөвшөөрөл сунгуулах 38, шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 44, түдгэлзүүлэх 2, хэрэглэгч шилжүүлэх 1, нийт 85 асуудлыг хууль тогтоомж болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд шийдвэрлэжээ. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын зөвшөөрлийн хүсэлт, тайлан мэдээ хүлээн авах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх, байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах зориулалт бүхий 3 төрлийн программ хангамжийг нийт 220.0 сая төгрөгөөр хийлгэж, ашиглалтад оруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	788,726,304.77	576,936,688.20
1.1.2	Дансны авлага	964,298,058.97	790,987,070.67
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	983,250.00	67,289.48
1.1.4	Бусад авлага	675,155,905.69	3,878,874.71
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	27,580,286.22	42,554,038.03
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,456,743,805.65	1,414,423,961.09
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	212,888,749.85	765,173,009.12
1.2.2	Биет бус хөрөнгө	165,000.00	220,000,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	213,053,749.85	985,173,009.12
1.3	Нийт хөрөнгийн дүн	2,669,797,555.50	2,399,596,970.21
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	804,852,810.95	600,291,991.39
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	663,816.84	28,980,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	805,516,627.79	629,271,991.39
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	805,516,627.79	629,271,991.39
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,864,260,927.71	1,770,304,978.82
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,864,280,927.71	1,770,324,978.82
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,669,797,555.50	2,399,596,970.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,491,042,585.71	2,672,615,953.55
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	2,491,042,585.71	2,672,615,953.55
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	7,641,438.29	18,460,262.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,240,487,355.28	2,807,032,164.44
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	258,196,668.72	(115,955,948.89)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	258,196,668.72	(115,955,948.89)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	258,196,668.72	(115,955,948.89)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	258,196,668.72	(115,955,948.89)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	8,029,219.75	1,526,543,781.11	1,534,593,000.86
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	20,000.00	8,029,219.75	1,526,543,781.11	1,534,593,000.86
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	258,196,668.72	258,196,668.72
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	63,462,038.38	-	63,462,038.38
9	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	20,000.00	71,491,258.13	1,792,769,669.58	1,864,280,927.71
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	22,000,000.00	22,000,000.00
11	Залруулсан үлдэгдэл	20,000.00	71,491,258.13	1,814,769,669.58	1,886,280,927.71
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(115,955,948.89)	(115,955,948.89)
17	2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	20,000.00	71,491,258.13	1,698,813,720.69	1,770,324,978.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,437,302,787.13	2,594,134,470.94
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,421,566,609.84	2,555,872,896.94
	Бусад мөнгөн орлого	15,736,177.29	38,261,574.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,184,993,596.07	2,590,252,587.51
	Ажиллагчдад төлсөн	1,173,698,618.46	1,470,928,986.23
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	164,448,313.41	203,776,012.34
	Бараа материал худалдан авахад төлсөн	9,666,607.00	24,593,066.27
	Ашиглалтын зардалд төлсөн	7,118,314.93	149,439,737.23
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,793,567.50	24,197,966.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	117,796,468.37	142,935,164.01
	Даатгалын төлбөрт төлсөн	115,830.00	-
	Бусад мөнгөн зарлага	680,355,876.40	574,381,655.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	252,309,191.06	3,881,883.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	215,671,500.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	215,671,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(215,671,500.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	252,309,191.06	(211,789,616.57)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	536,417,113.71	788,726,304.77
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	788,726,304.77	576,936,688.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			2,498,684.0	2,780,748.8	2,691,076.2	192,392.2	107.7	(89,672.6)	96.8
1	Үүнээс: Цэвэр орлого	м.төг	2,491,042.6	2,780,748.8	2,645,215.4	154,172.8	106.2	(135,533.4)	95.1
	Бусад орлого	м.төг	7,641.4	-	45,860.8	38,219.4	600.2	45,860.8	-
2	Нийт орлого	м.төг	2,498,684.0	2,780,748.8	2,691,076.2	192,392.2	107.7	(89,672.6)	96.8
3	Нийт зардал	м.төг	2,240,487.4	2,780,748.8	2,807,032.2	566,544.8	125.3	26,283.4	100.9
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	2,240,487.4	2,780,748.8	2,807,032.2	566,544.8	125.3	26,283.4	100.9
4	Татварын өмнөх ашиг	м.төг	258,196.7	-	(115,955.9)	(374,152.6)	(44.9)	(115,955.9)	-
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	258,196.7	-	(115,955.9)	(374,152.6)	(44.9)	(115,955.9)	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	-	-	206,083.0	206,083.0	-	206,083.0	-
	в/ НДШ	м.төг	163,561.9	235,348.7	204,759.3	41,197.4	125.2	(30,589.5)	87.0
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	377.2	-	1,323.8	946.6	351.0	1,323.8	-
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	28.0	30.0	30.0	2.0	107.1	-	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	1,287,296.8	1,711,324.0	1,636,272.5	348,975.6	127.1	(75,051.5)	95.6
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,831.2	4,753.7	4,545.2	714.0	118.6	(208.5)	95.6
13	Нийт авлага	м.төг	1,640,437.2	-	794,933.2	-	48.5	794,933.2	-
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	805,516.6	-	629,272.0	-	78.1	629,272.0	-
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлэхүйц, Монгол хүний эрхийг хангасан баталгаатай, тэгш, хүртээмжтэй усны үйлчилгээг үр өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх оновчтой зохицуулалтыг хийх үндсэн зорилготой байгууллага юм. Энэхүү зорилгын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг тогтоох
- Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- Мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах;
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн байгууллага, албан газар гэсэн статустай, 100 хувь төрийн өмчит байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Тус хорооны удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант хугацаанд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны ажилчдын хувийн хэргийн бүрдэл, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хөрөнгийн зарцуулалт, цалингийн тооцоолол, захирлын А болон Б тушаалын хэрэгжилттэй холбоотой зөвлөмж, сайжруулах үүрэг чиглэл өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж, ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 270.2 сая төгрөгөөр буюу 10 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	788,726.3	576,936.7	(211,789.6)
Авлага	1,640,437.2	794,933.2	(845,504.0)
Бараа материал	27,580.3	42,554.0	14,973.8
Үндсэн хөрөнгө	213,053.7	985,173.0	772,119.3
Нийт хөрөнгө	2,669,797.6	2,399,597.0	(270,200.6)
Өглөг	805,516.6	629,272.0	(176,244.6)
Эздийн өмч	1,864,280.9	1,770,325.0	(93,975.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,669,797.6	2,399,597.0	(270,220.6)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 576.9 сая төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 211.8 сая төгрөгөөр буурсан нь эрдэм шинжилгээний зардлын өсөлттэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 794.9 сая төгрөг болж, 845.5 сая төгрөгөөр буурсан нь авлагын барагдуулалт сайжирсантай холбоотой. Авлагын үлдэгдэлд байгууллагаас авлага 791.0 сая төгрөг, хувь хүнээс авах авлага 3.9 сая төгрөг байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 42.6 сая төгрөг болж, 15.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 67.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан, үйл ажиллагаандаа 53.3 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 985.2 сая төгрөг болж, 772.1 сая төгрөгөөр өссөн нь:
 - ✓ Тайлант онд өөрийн хөрөнгөөр 248.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;

- ✓ Өмнөх оны аудитын шийдвэрээр авлагаар бүртгэгдсэн байсан 670.9 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- ✓ Тайлант хугацаанд 147.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 629.3 сая төгрөг болж, 176.2 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг буурсантай холбоотой;
- Эздийн өмч дансны үлдэгдэл 1,770.3 сая төгрөг болж, 94.0 сая төгрөгөөр буурсан нь:
 - ✓ Тайлант хугацааны 116.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
 - ✓ Өмнөх онд зардлаар бүртгэсэн программ хангамжийн өртгийн 22.0 сая төгрөгийн алдааны залруулгаар хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Биет бус хөрөнгө: Программ хангамжийн талаарх судалгаа авахад программ хангамж байхгүй гэж ирүүлсэн. Харин аудитын залруулгаар 2024-2025 онд “Аствишн” ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлсэн 220.0 сая төгрөгийн программыг хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр 9.10-т “Зохицуулах хороо жил бүр тухайн жилийн үйл ажиллагааны төсвөө баталж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлагнана” гэж заасны дагуу Зохицуулах хороо 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 2,780.7 сая төгрөг, нийт зардлыг 2,780.7 сая төгрөг, ашиг, алдагдалгүй ажиллахаар төлөвлөж, баталсан байна.

Гүйцэтгэлээр 2,691.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,807.0 сая төгрөгийн зардал гаргаж, 115.9 сая төгрөгийн татварын дараах алдагдал тайлагнасан.

Нийт орлогын төлөвлөгөө 89.7 сая төгрөг буюу 3.2 хувиар тасарч, зардлын гүйцэтгэл 26.3 сая төгрөгөөр хэтэрсэн. Үүнд: Тайлант хугацааны элэгдлийн зардал 147.5 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаагүй, эрдэм шинжилгээ судалгааны зардал 65.8 сая төгрөгөөр хэтэрсэн, цалингийн зардал 75.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 30.6 сая төгрөг, тавилга эд хогшлын худалдан авалт 39.9 сая төгрөг, гадаад томилолтын зардал 7.9 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Тус байгууллага 2025 онд 26 орон тоотой ажиллахаар батлагдаж, 24 орон тоотой ажилласан байна. Нийт цалингийн зардлыг 1,711.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,636.3 сая төгрөгийг зарцуулж, 75.0 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар ажилчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 9.0 мянган төгрөгөөр, унааны хөнгөлөлтийг 1.0 мянган төгрөгөөр, нийт 10.0

мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 53.2 сая төгрөгийг зарцуулсан байна;

- Гадаад томилолт, хэвлэл мэдээллийн зардалд 101.2 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 93.2 сая төгрөг зарцуулсан. Аяллын компанид 38.5 сая төгрөг шилжүүлсэнд албан шаардлага хүргүүлсэн.
- Хурал, цуглаан форумын үйл ажиллагаанд 128.9 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 115.1 сая төгрөг зарцуулсан.
- Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд “Мянгат хүлэг” ХХК-тай 4.0 сая төгрөгийн гэрээ байгуулж Малчин ТВ-ээр нэвтрүүлэг хийлгэсэн.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй болно.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчилгээ үзүүлэх асуудлаар нэр бүхий 3 байгууллагатай худалдан авалт хийх “Үйлчилгээ үзүүлэх” 164.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, өөрийн эх үүсвэрээс 153.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэн гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Азуре хүлэг аудит” ХХК-ийн аудитор Д.Мөнхзул гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Батбилэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 2,240.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 22.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байр ашиглалтын зардал 4.2 сая, бичиг хэргийн зардал 7.1 сая, урсгал засвар 2.5 сая, төвлөрсөн арга хэмээний зардал 12.5 сая төгрөгөөр тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 513.1 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд байршуулж, ил тод мэдээлэх ёстой 136 мэдээллээс 82 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 54 нь мэдээллийг байршуулаагүй. Үүнд: Нийт 37 тушаалыг (А – 20, Б – 17) мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 204.6 сая төгрөгийн 10 гүйлгээ, 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 26.4 сая төгрөгийн 4 гүйлгээ, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 282.6 сая төгрөгийн 16 гэрээний мэдээллийг тус тус байршуулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо нь 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулагдсан. Аудитаар 9.9 сая төгрөгийн 1 залруулга хийсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,110.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
				Хувь	
Акт	2	9,893.9	2	9,893.9	100.0
Албан шаардлага	3	1,110,739.0	3	1,110,739.0	100.0
Нийт дүн	5	1,120,632.9	5	1,120,632.9	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоогоор гүйцэтгүүлэхээр 19.3 сая төгрөг шилжүүлсэн ажил үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнг;
- Орон тооны бус гишүүдэд үр дүнгийн урамшуулал олгосон эсэхийг анхаарах хэрэгтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 220.0 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа: Гэрээгээр гүйцэтгүүлсэн 220.0 сая төгрөгийн программ хангамжийг тайлант хугацааны зардлаар буруу бүртгэсэн.

Энэ нь НББОУС 1.15-д “Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”-д гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 399.9 сая төгрөгийн зөрчил², 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 328.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага, 69.4 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 399.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22.4 сая төгрөгөөс их тул “Хязгаарлалтай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1:

Хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулах гэрээг 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, урьдчилгаа төлбөрт 1.2 сая төгрөг шилжүүлсэн байна. Гэрээний хугацаа 2025 оны 5 дугаар сарын 13-нд дууссан бөгөөд Зохицуулах хороо нь хийлгэсэн баримт бичиг нь тус байгууллагын онцлогт нийцээгүй, шаардлага хангаагүй гэж үзэн уг ажлыг хүлээн аваагүй байна. Гэрээний 5 дугаар зүйлийн 5.3-т “Хэрэв Гүйцэтгэгч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй 7 хоног хэтэрсэн, эсхүл ийнхүү биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах учирсан хохирлоо нэхэмжилнэ” гэх заалтыг үндэслэн урьдчилгаа төлбөрийг буцаан авах асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээн үүргээ биелүүлээгүй, ажлын урьдчилгаа төлбөрт олгосон дүнг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт 2:

Тайлант хугацаанд нэр бүхий 3 ажилтанд амралтын болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 0.9 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлс, тэтгэмж зөрүүтэй тооцож олгосон 0.9 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1:

БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд оролцох томилолтын зардал 38.5 сая төгрөгийг бизнес аяллын компанид шилжүүлж, үйлчлүүлсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3. "Унааны зардлыг тухайн чиглэлд үйлчлэх нисэх онгоц, галт тэрэг, автомашин, автобусны үнийн тарифаар, байр, хоолны зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тарифыг баримтлан тус тус тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад томилолтоор явахдаа бизнес аяллын компаниар үйлчлүүлж, хөрөнгийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2:

Жилийн эцэст харилцагч байгууллагуудаас авах 13.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "заасан эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3:

Тус байгууллагын 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 65.8 сая төгрөгөөр хэтрүүлж, 115.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн зорилтот түвшнийг бодитой төлөвлөдөггүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг хэтрүүлдэг зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 4:

Тус хорооны даргын 2025 оны А/75 дугаар тушаалаар 138.1 сая төгрөгийн нэмэгдэл цалин давхардуулан олгосон, оны шилдэг ажилтан шалгаруулж 20.8 сая төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай уялдуулаагүй, давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 5:

Мэдээлэл технологийн ажилтны чиг үүрэгт заасан ажлыг давхардуулж, байгууллагын жилийн ажлын тайланг танилцуулах бичлэг хийлгэхээр иргэнтэй гэрээ байгуулж, 1.5 сая төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж тус тус заасантай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Ажилтны ажил үүргийн хуваарьт тусгагдсан чиг үүргийг давхардуулж гэрээгээр гүйцэтгүүлсэн зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цалингийн зардлын данстай холбоотой:

Илрүүлэлт 1:

Тус хорооны даргын тушаалаар 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдөр нэр бүхий 14 ажилтанд 45.3 сая төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгож, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан. Хөдөлмөрийн дотоод журамдаа 2025 онд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж, цаашид 2 жил ажилласан ажилтан бүр нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал авч байхаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлаас зориулалт бус зарцуулж, урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх.

Тээвэр шатахууны зардлын данстай холбоотой:

Илрүүлэлт 2:

Авто тээврийн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм мөрдөөгүйгээс тайлант хугацаанд автомашины сэлбэгийн зардалд 24.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах, тэдгээрийн биелэлтийг хангуулах”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Авто тээврийн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-ын 5.3, 5.4, 5.5-д заасан норм нормативыг баримтлаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэл, сэлбэг эд ангийн ашиглалтын норм, нормативыг мөрдөж ажиллаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Гэрээгээр гүйцэтгүүлсэн 220,000.0 мянган төгрөгийн программ хангамжийг тайлант хугацааны зардлаар буруу бүртгэсэн.	1	220,000.0	-	-	1	220,000.0	1	220,000.0	-	-	-	-
	Дүн	1	220,000.0	-	-	1	220,000.0	1	220,000.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд оролцох томилолтын зардал 38.5 сая төгрөгийг бизнес аялын компани руу шилжүүлсэн.	1	38,500.0	-	-	1	38,500.0	-	-	-	-
Хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулах гэрээг 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, урьдчилгаа төлбөрт 1,200.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Гэрээний хугацаа 2025 оны 5 дугаар сарын 13-нд дууссан бөгөөд Зохицуулах хороо нь хийлгэсэн баримт бичиг нь тус байгууллагын онцлогт нийцээгүй, шаардлага хангаагүй гэж үзэн уг ажлыг хүлээн аваагүй байна. Гэрээний 5 дугаар зүйлийн 5.3-т “Хэрэв Гүйцэтгэгч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй 7 хоног хэтэрсэн, эсхүл ийнхүү биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах учирсан хохирлоо	1	1,200.0	1	1,200.0	-	-	-	-	-	-

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

нэхэмжилнэ” гэх заалтыг үндэслэн урьдчилгаа төлбөрийг буцаан авах асуудлыг шийдвэрлээгүй байна.										
Тайлант хугацаанд нэр бүхий 3 ажилтанд амралтын болоод хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж зөрүүтэй тооцож олгосон.	1	881.1	1	881.1	-	-	-	-	-	-
Тус хорооны даргын тушаалаар 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдөр нэр бүхий 14 ажилтанд 45,300.0 мянган төгрөгийн нэмэгдэл урамшууллыг цалингийн зардлаас олгосон, Хөдөлмөрийн дотоод журамдаа 2025 онд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж, цаашид 2 жил ажилласан ажилтан бүр нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал авч байхаар тусгасан байна.	1	45,300.0	-	-	-	-	1	45,300.0	-	-
Авто тээврийн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм мөрдөөгүйгээс тайлант хугацаанд автомашины сэлбэгийн зардалд 24,118.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.	1	24,118.0	-	-	-	-	1	24,118.0	-	-
Жилийн эцэст харилцагч байгууллагуудаас авах авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.	1	13,505.2	-	-	1	13,505.2	-	-	-	-
Тус байгууллагын 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 65,854.5 мянган төгрөгөөр хэтрүүлж, 115,955.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	115,955.9	-	-	1	115,955.9	-	-	-	-
Тус хорооны даргын 2025 оны А/75 дугаар тушаалаар 138,133.3 мянган төгрөгийн нэмэгдэл цалин давхардуулан олгосон, оны шилдэг ажилтан шалгаруулж 20,790.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон байна.	1	158,923.3	-	-	1	158,923.3	-	-	-	-
Мэдээлэл технологийн ажилтны чиг үүрэгт заасан ажлыг давхардуулж байгууллагын жилийн ажлын тайланг танилцуулах бичлэг хийлгэхээр иргэнтэй гэрээ байгуулж, 1,500.0 мянган төгрөг зарцуулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.	1	1,500.0	-	-	1	1,500.0	-	-	-	-
Дүн	9	399,883.5	2	2,081.1	5	328,384.4	2	69,418.0	-	-

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны цахим системд байршуулж ил тод мэдээлэх ёстой 136 мэдээллээс 82 нь мэдээлэгдсэн, 54 нь мэдээлэгдээгүй байна. Үүнд: Нийт 37 тушаал (А – 20, Б – 17) огт мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 204,570.6 мянган төгрөгийн 10 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 26,433.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 282,615.9 мянган төгрөгийн 16 гэрээний мэдээллийг тус тус байршуулж тайлагнаагүй байна. Мөн хугацаа хоцроож тайлагнасан 3 мэдээлэл байна.	1	513,619.8	-	-	1	513,619.8	-	-
Дүн	1	513,619.8	-	-	1	513,619.8	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 913/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/79/НА -СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст харилцагч байгууллагуудаас авах 13,505,184.00 /Арван гурван сая таван зуун таван мянга нэг зуун наян дөрвөн/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "заасан эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Г.МӨНХБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Sh aardlaga 2026/0316 SAG-68 Docx

1526181218



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 912/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/79/ИА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд байршуулж, ил тод мэдээлэх ёстой 136 мэдээллээс 82 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 54 нь мэдээллийг байршуулаагүй. Үүнд: Нийт 37 тушаалыг (А – 20, Б – 17) мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 204,570,600.00 /хоёр зуун дөрвөн сая таван зуун далан мянга зургаан зуун/ төгрөгийн 10 гүйлгээ, 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 26,433,200.00 /хорин зургаан сая дөрвөн зуун гучин гурван мянга хоёр зуун/ төгрөгийн 4 гүйлгээ, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 282,615,900.00 /хоёр зуун наян хоёр сая зургаан зуун арван таван мянга есөн /зуун/ төгрөгийн 16 гэрээний мэдээллийг тус тус байршуулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй болон хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
ATA16087
9025081411

Z. Alban Shaardlaga 2026/0316.SAG-68.Docx

1526181226



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 911/А015 0185

Улаанбаатар хот

САГ - 2026/79/НА - СТА - ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг 65,854,457.90 (жаран таван сая найман зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун тавин долоо төгрөг ерэн мөнгө) төгрөгөөр хэтрүүлж, 115,955,948.89 /нэг зуун арван таван сая есөн зуун тавин таван мянга есөн зуун дөчин найман төгрөг наян есөн мөнгө/ төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Эдийн засгийн зорилтот түвшнийг бодитой төлөвлөдөггүй, эрдэм шинжилгээ судалгааны зардлыг хэтрүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9024109
90216087
9025081411

Z. Alban Shaardlaga 2026/0316 SAG-68.Docx

1526191220



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 910/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/79/НА-СТА-ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хорооны даргын 2025 оны А/75 дугаар тушаалаар 138,133,300.00 /нэг зуун гучин найман сая нэг зуун гучин гурван мянга гурван зуун/ төгрөгийн нэмэгдэл цалин давхардуулан олгосон, оны шилдэг ажилтан шалгаруулж 20,790,000.00 /хорин сая долоон зуун ерэн мянган/ төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдэл цалин, урамшууллыг байгууллагын гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай уялдуулаагүй, давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-269230

902508109
9025081411

Z. Alban Shaardlaga 2026-0316 SAG-68 Docx

1526181222



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 909/АД150185

Улаанбаатар хот

САГ -2026/79/КА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд оролцох томилолтын зардал 38,500,000.00 /гучин найман сая таван зуун мянган/ төгрөгийг бизнес аяллын компани руу шилжүүлсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3. "Унааны зардлыг тухайн чиглэлд үйлчлэх нисэх онгоц, галт тэрэг, автомашин, автобусны үнийн тарифаар, байр, хоолны зардлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тарифыг баримтлан тус тус тооцно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Томилолтын зардлыг бизнес аяллын компаниар руу шилжүүлж, хөрөнгө зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0316.SAG-68.Docx

1526191216



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 908/АД150185

Улаанбаатар хот

САГ -2026/79/НА -СТА -ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэдээлэл технологийн ажилтны чиг үүрэгт заасан ажлыг давхардуулж, байгууллагын жилийн ажлын тайланг танилцуулах бичлэг хийлгэхээр иргэнтэй гэрээ байгуулж, 1,500,000.00 /нэг сая таван зуун мянган/ төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилтны ажил үүргийн хуваарьт тусгагдсан чиг үүргийг давхардуулж гэрээгээр гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Г.МӨНХБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga 2026/0316 SAG-68 Docx

1526181224



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 186/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/79/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулах гэрээг 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр байгуулж, урьдчилгаа төлбөрт 1,200,000.00 /Нэг сая хоёр зуун мянган/ төгрөг шилжүүлсэн байна. Гэрээний хугацаа 2025 оны 5 дугаар сарын 13-нд дууссан бөгөөд Зохицуулах хороо нь хийлгэсэн баримт бичиг нь тус байгууллагын онцлогт нийцээгүй, шаардлага хангаагүй гэж үзэн уг ажлыг хүлээн аваагүй байна. Гэрээний 5 дугаар зүйлийн 5.3-т "Хэрэв Гүйцэтгэгч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй 7 хоног хэтэрсэн, эсхүл ийнхүү биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд Захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлах учирсан хохиролоо нэхэмжилнэ" гэх заалтыг үндэслэн урьдчилгаа төлбөрийг буцаан авах асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлын урьдчилгаа төлбөрт олгосон 1,200,000.00 /Нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийг гэрээг байгуулсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын дарга Д.Баттулга, гэрээг баталсан хорооны дарга Г.Цогтсайхан нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 187/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/79/ИА - СТА - ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий 3 ажилтанд амралтын болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 881,131.00 /Найман зуун наян нэгэн мянга нэг зуун гучин нэгэн/ төгрөгөөр зөрүүтэй тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Цалин хөлс, тэтгэмж зөрүүтэй тооцож олгосон 881,131.00 /Найман зуун наян нэгэн мянга нэг зуун гучин нэгэн/ төгрөгийг тооцоолол хийсэн нягтлан бодогч Г.Энхчимэг, шийдвэр гаргасан дарга Г.Цогтсайхан нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны дарга /Г.Цогтсайхан/, нягтлан бодогч /Б.Булганзаяа/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.МӨНХБАЯР

